ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/28/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2024 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын<br>тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br>Аудитын менежер : Х.Болдбаатар<br>Утас:99105506<br>Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ц.Оюунсувд<br>Утас: 99076038<br>Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn<br>Аудитор : Г.Уранбаяр<br>Утас:95183025<br>Цахим хаяг:gonchigdorjuranbayr@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........ 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4

  2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

  2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4

  2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 5

  2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6

  2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........ 8

  3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 8

  3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин........ 10

  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........ 10

  3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........ 11

4. Аудитын тайлан........ 13

  4.1 Ерөнхий зүйл ........ 13

  4.2 Материаллаг байдал ........ 14

  4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........ 14

  4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14

  4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

  4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16

5. Аудитын илрүүлэлт ........ 16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........ **16**


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn


2024.02.23 № 143

танай ________ -ны № ________ -т

ЗАВХАН АЙМГИЙН ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН ТЕАТРЫН ДАРГА Г.СОЛОНГО-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 1,342.7 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 148.8 сая төгрөгийн, нийт 1,491.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, зарцуулсан байна. Тайлант онд тус театр нь “Огторгуйн Цагаан Гарьд сан”-ийн санхүүжилтээр 19.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө болон 385.8 сая төгрөгийн материал хүлээн авч, “Асрын өндөр” жүжгийг найруулан ард иргэдийн хүртээл болгосон байна.

**Аудитын гол асуудал**

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд олгох мөнгөн тэтгэмжийг төрийн үйлчилгээний ажилчид болон нийгмийн даатгал бүрэн төлөөгүй ажилчдад олгосон зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Бараа материалын хөдөлгөөний бүртгэлийг УСНББОУС-12 Бараа материал-д заасны дагуу бүртгээгүй байна.

0130°0°41

Audit(D)Дүгнэлт/2024

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**2023 оны 12 дугаар сарын 31** **/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **317,691,112.42** | **899,733,336.48** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 13,977,752.62 | 159,509,338.18 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 13,977,752.62 | 159,509,338.18 |
| **3121** | **Төгрөг** | 13,977,752.62 | 159,509,338.18 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 13,977,752.62 | 159,509,338.18 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 303,713,359.80 | 740,223,998.30 |
| **351** | **Түүхий эд материал** | 95,887,470.00 | 191,677,870.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 95,887,470.00 | 191,677,870.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 553,650.00 | 389,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 207,272,239.80 | 548,157,128.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 507,250.00 | 421,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,442,850.00 | 1,735,600.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 275,000.00 | 275,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,225,600.00 | 4,008,700.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 202,821,539.80 | 541,716,628.30 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **590,706,362.15** | **536,186,986.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 590,706,362.15 | 536,186,986.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 553,808,028.82 | 499,548,652.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 451,792,031.47 | 451,792,031.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (225,896,015.52) | (280,111,059.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 30,913,900.00 | 30,913,900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (6,413,900.00) | (12,413,900.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 362,496,323.90 | 397,758,068.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (248,063,054.75) | (290,320,333.21) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,238,376.58 | 96,243,376.58 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (70,723,158.24) | (72,776,957.06) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 179,192,594.03 | 179,192,594.03 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (729,068.65) | (729,068.65) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 36,898,333.33 | 36,638,333.29 |
| 39301 | Програм хангамж | 1,300,000.00 | 1,300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (21,666.67) | (281,666.71) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,390,000.00 | 36,390,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (770,000.00) | (770,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **908,397,474.57** | **1,435,920,322.59** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **10,005.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 10,005.00 | - |
| **413** | **Өглөг** | 10,005.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 10,005.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **908,387,469.57** | **1,435,920,322.59** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 908,387,469.57 | 1,435,920,322.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 711,463,258.50 | 711,463,258.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 711,463,258.50 | 711,463,258.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (193,227,925.49) | 334,304,927.53 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (213,605,802.31) | (193,227,925.49) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 20,377,876.82 | 527,532,853.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 390,152,136.56 | 390,152,136.56 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **908,397,474.57** | **1,435,920,322.59** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| **Дансны код** | | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,120,571,327.26** | **1,968,911,350.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **97,983,827.26** | **477,315,946.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 97,983,827.26 | 449,315,946.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 97,983,827.26 | 449,315,946.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 59,183,927.26 | 43,597,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 800,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 37,999,900.00 | 405,718,446.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | - | 28,000,000.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | - | 28,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,022,587,500.00** | **1,491,595,404.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 813,982,700.00 | 1,342,720,604.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 813,982,700.00 | 1,342,720,604.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 208,604,800.00 | 148,874,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 181,681,800.00 | 148,874,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 26,923,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,096,534,299.52** | **1,441,378,496.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,096,534,299.52** | **1,441,378,496.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,074,422,153.11 | 1,282,901,718.93 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 636,704,831.45 | 852,793,039.50 |
| 210101 | Үндсэн цалин | 487,518,719.20 | 603,316,211.50 |
| 210102 | Нэмэгдэл | 82,297,289.92 | 122,739,752.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,032,000.00 | 42,422,780.00 |
| 210104 | Урамшуулал | 33,856,822.33 | 84,314,296.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,553,253.00 | 108,629,182.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,776,239.84 | 74,506,091.89 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,444,228.29 | 8,879,848.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,155,362.64 | 6,993,938.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,288,865.65 | 1,589,307.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,888,556.58 | 16,659,995.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 175,586,098.85 | 145,289,041.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,767,218.85 | 13,719,761.95 |
| 210302 | Түлш, халаалт | 156,689,720.00 | 122,337,150.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,129,160.00 | 9,232,130.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,785,881.00 | 10,893,452.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,171,680.00 | 1,308,930.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,201,337.00 | 3,195,805.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 480,370.00 | 514,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 240,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 731,100.00 | 754,450.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,201,394.00 | 4,879,167.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,151,778.00 | 10,310,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,013,740.00 | 3,600,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,432,600.00 | 467,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,705,438.00 | 6,243,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,349,100.00 | 11,352,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,349,100.00 | 11,352,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,291,303.00 | 13,073,541.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,907,998.00 | 7,649,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | 863,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 155,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 256,325.00 | 53,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 598,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 320,580.00 | 3,753,116.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 126,999,907.81 | 130,560,711.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,426,000.00 | 15,774,590.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 10,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 103,573,907.81 | 104,786,121.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,112,146.41 | 158,476,778.05 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,045,800.00 | 157,014,820.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 14,008,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,355,800.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 142,006,620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 690,000.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 843,619.15 | 1,461,958.05 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 843,619.15 | 1,461,958.05 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 222,727.26 | - |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 222,727.26 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **24,037,027.74** | **527,532,853.02** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 3,659,150.92 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,339,150.92 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 320,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (3,659,150.92) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **20,377,876.82** | **527,532,853.02** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,082,831,427.26** | **1,563,192,904.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,243,927.26** | **71,597,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 60,243,927.26 | 43,597,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 60,243,927.26 | 43,597,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 59,443,927.26 | 43,597,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 800,000.00 | - |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | - | 28,000,000.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | - | 28,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,022,587,500.00** | **1,491,595,404.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 813,982,700.00 | 1,342,720,604.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 813,982,700.00 | 1,342,720,604.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 208,604,800.00 | 148,874,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 181,681,800.00 | 148,874,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 26,923,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,041,504,074.64** | **1,387,284,573.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,041,504,074.64** | **1,387,284,573.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,019,391,928.23** | **1,228,807,795.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 636,102,331.38 | 852,803,044.50 |
| 210101 | Үндсэн цалин | 486,916,219.13 | 603,306,216.50 |
| 210102 | Нэмэгдэл | 82,297,289.92 | 122,739,752.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,032,000.00 | 42,442,780.00 |
| 210104 | Урамшуулал | 33,856,822.33 | 84,314,296.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,553,253.00 | 108,629,182.94 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,776,239.84 | 74,506,091.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,444,228.29 | 8,879,848.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,155,362.64 | 6,993,938.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,288,865.65 | 1,589,307.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,888,556.58 | 16,659,995.92 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 175,586,098.85 | 145,289,041.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,767,218.85 | 13,719,761.95 |
| 210302 | Түлш, халаалт | 156,689,720.00 | 122,337,150.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,129,160.00 | 9,232,130.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,802,237.00 | 5,493,985.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,194,530.00 | 1,222,880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,201,337.00 | 2,395,805.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 480,370.00 | 514,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 250,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 240,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 676,000.00 | 1,120,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 309,000.00 | 929,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 309,000.00 | 929,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,716,028.00 | 15,393,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,770,740.00 | 6,469,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,573,050.00 | 1,537,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,372,238.00 | 7,386,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,349,100.00 | 11,352,450.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,349,100.00 | 11,352,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 43,791,480.00 | 76,930,391.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 42,397,380.00 | 71,506,650.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | 863,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 155,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 288,400.00 | 53,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 598,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 299,300.00 | 3,753,116.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,182,400.00 | 11,987,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,182,400.00 | 1,987,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 10,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,112,146.41** | **158,476,778.05** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,045,800.00 | 157,014,820.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 14,008,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,355,800.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 142,006,620.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 690,000.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 843,619.15 | 1,461,958.05 |
| 213402 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 843,619.15 | 1,461,958.05 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 222,727.26 | - |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 222,727.26 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **41,327,352.62** | **175,908,330.56** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **29,638,000.00** | **30,376,745.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **29,638,000.00** | **30,376,745.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 29,638,000.00 | 30,376,745.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 29,638,000.00 | 30,376,745.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(29,638,000.00)** | **(30,376,745.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 11,689,352.62 | 145,531,585.56 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 2,288,400.00 | 13,977,752.62 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 13,977,752.62 | 159,509,338.18 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 711,463,258.50 | 401,821,666.19 | (213,605,802.31) | 899,679,122.38 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **711,463,258.50** | **401,821,666.19** | **(213,605,802.31)** | 899,679,122.38 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | (11,669,529.63) | - | (11,669,529.63) |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 20,377,876.82 | 20,377,876.82 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **711,463,258.50** | **390,152,136.56** | **(193,227,925.49)** | 908,387,469.57 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **711,463,258.50** | **390,152,136.56** | **(193,227,925.49)** | 908,387,469.57 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **711,463,258.50** | **390,152,136.56** | **(193,227,925.49)** | 908,387,469.57 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 527,532,853.02 | 527,532,853.02 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **711,463,258.50** | **390,152,136.56** | **334,304,927.53** | 1,435,920,322.59 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,595,890,700.00 | 1,416,199,360.39 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,595,890,700.00 | 1,416,199,360.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,438,875,900.00 | 1,259,184,540.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 993,600,700.00 | 852,803,044.50 |
| 210101 | Үндсэн цалин | 640,703,100.00 | 603,306,216.50 |
| 210102 | Нэмэгдэл | 165,578,700.00 | 122,739,752.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,324,000.00 | 42,442,780.00 |
| 210104 | Урамшуулал | 128,994,900.00 | 84,314,296.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 123,566,500.00 | 108,629,182.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,302,700.00 | 74,506,091.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,816,000.00 | 8,879,848.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,852,900.00 | 6,993,938.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,963,000.00 | 1,589,307.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,631,900.00 | 16,659,995.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 146,751,000.00 | 145,289,041.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,734,200.00 | 13,719,761.95 |
| 210302 | Түлш, халаалт | 122,331,900.00 | 122,337,150.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,684,900.00 | 9,232,130.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,525,000.00 | 5,493,985.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,225,000.00 | 1,222,880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,365,000.00 | 2,395,805.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 605,200.00 | 514,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,300.00 | 240,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,089,500.00 | 1,120,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 929,000.00 | 929,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 929,000.00 | 929,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 61,105,700.00 | 45,770,045.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 38,006,100.00 | 22,766,145.00 |
| 210602 | Тавилга | 14,080,000.00 | 14,080,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,632,800.00 | 1,537,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,386,800.00 | 7,386,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,382,000.00 | 11,352,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,382,000.00 | 11,352,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 82,026,000.00 | 76,930,391.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,059,300.00 | 71,506,650.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 863,600.00 | 863,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,000.00 | 155,025.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 53,500.00 | 53,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 980,000.00 | 598,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,876,600.00 | 3,753,116.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,990,000.00 | 11,987,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,990,000.00 | 1,987,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 157,014,800.00 | 157,014,820.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 157,014,800.00 | 157,014,820.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 14,008,200.00 | 14,008,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 142,006,600.00 | 142,006,620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,599,114,900.00 | 1,342,720,604.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,599,114,900.00 | 1,342,720,604.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,599,114,900.00 | 1,342,720,604.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 13,977,752.62 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 43,591,500.00 | 43,597,500.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 234.00 | 226.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 2.00 | 2.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 2.00 | 2.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 116.00 | 112.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 98.00 | 94.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **116.00** | **112.00** |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 100.00 | 96.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 16.00 | 16.00 |

**2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан**

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь**:** "Тус театр нь удирдах албан тушаалтан1, гүйцэтгэх ажилтан 46, үйлчлэх ажилтан 13 гэсэн 60 хүний орон тоотой, бүжиг, драм, хөгжим, хор гэсэн уран бүтээлийн 4, аж ахуйн анги гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2021.11 дүгээр сард УГЗ Д.Гомбо агсны нэрэмжит орон нутгийн театр, чуулгуудын “Морин хуурын дөрвөл” хөгжимчдийн Улсын анхдугаар уралдаанд тус байгууллагын морин хуурын Дөрвөл амжилттай оролцож ДЭД байрын шагнал авсан онцлогтой жил болсон байна.

“САР БҮР- НЭГ УРАН БҮТЭЭЛ” туурвих төлөвлөгөөт ажлын хүрээнд гоцлол номероор 370, хамтарсан 96 уран бүтээлээр уран бүтээлийн урын сангийн баяжуулан ажилласан байна.

**Зорилго:** Ардын уламжлалт зан заншил, соёл урлагаа, дэлхийн сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, иргэдийн оюун санааны хөгжлийг тэтгэхэд оршино. ХЖТ нь иргэд соёл урлагаар үйлчлэх чиг үүрэгтэй.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Хөгжимт жүжгийн театрын даргын дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 486,777.20 мянган төгрөгөөр буюу 33,6 хувиар *өссөн* байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.00 | 2.00 | 3=2-1 |
| Бараа материал | 303,713.40 | 740,223.90 | (436,510.50) |
| Үндсэн хөрөнгө | 1,143,323.20 | 1,193,589.90 | (50,266.70) |
| **Нийт хөрөнгө** | 1,447,036.60 | 1,933,813.80 | (486,777.20) |
| Өр төлбөр | 10.00 | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 908,387.50 | 1,435,920.30 | (527,532.80) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 908,397.40 | 1,435,920.30 | (527,522.90) |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 303,713.40 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 81,364.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй 385,828.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулсан 30,682.7 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 740,223.9 мянган төгрөг болж өмнөх оноос 436,510.5 мянган төгрөгөөр өссөж, акталж устгасан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр 30,376,7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 19,890.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, жилийн эцэст 1,933,813.80 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 104,786.1 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 527,522.90 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,342,720.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 148,874.8 мянган төгрөгийн зарлагыг тооцон нийт 1,491,595.3 төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,342,720.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,320,508.4 мянган төгрөг буюу 98 хувийн гүйцэтгэлтэй

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71702** | **ХЖТеатр** | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,086,326.20 | 1,086,326.20 | **-** | **100%** |
| 80214 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ /уран бүтээлийн зардал/ | 20,000.00 | 19,986.00 | **14.00** | **100%** |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 1,000.00 | 1,000.00 | **-** | **100%** |
| 81855 | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт | 93,387.80 | 71,189.70 | **22,198.10** | **90%** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж | 142,006.50 | 142,006.50 | **-** | **100%** |
| | | 1,342,720.50 | 1,320,508.40 | **22,212.10** | **98%** |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71801** | **Сургуулийн өмнөх боловсрол** | | | | |
| 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 148,874.80 | 148,874.80 | **1,461.90** | **100%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг санхүүжүүлж 148,874.8 мянган төгрөг тоогтмол зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/Мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 5 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалт | 156,689.70 | 122,337.20 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгаан | 9,767.20 | 13,719.70 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр, бохир ус | 9,129.20 | 9,232.10 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Шууд худалдан авалт | Урсгал засвар | 2,124.00 | 2,124.00 |
| 9 | Шууд худалдан авалт | Харилцаа холбооны зардал | 480.40 | 514.80 |
| | ДҮН | | 178,190.50 | 147,927.80 |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2024 оны 02 дугээр сарын 11-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,096,534.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 16,448.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,336.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,939.2 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Албан шаардлага | 2 | 14,939.2 | 2 | 14,939.2 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **14,939.2** | **2** | **14,939.2** | **100** |

**Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,665.8 төгрөгийн алдаа илэрснээс 15,665.8 төгрөгийн акт тогтоолоо.

**5.1 Зөвлөмж хүргүүлээгүй**

**5.2 Албан шаардлага хүргүүлээгүй**

**5.3 Төлбөрийн акт**

Хөдөө орон нутагт ажилласны тэтгэмж буруу олгосон 15,665.8 төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| хөдөө орон нутагт ажилласны тэтгэмж буруу олгосон | 1 | 15,665.8 | 1 | 15,665.8 | | | | | | | | |
| **Дүн** | **1** | 15,665.8 | **1** | 15,665.8 | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Г.УРАНБАЯР ОГНОО: 2024-02-22